



ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 23 өдөр

Дугаар А/141

Мандалговь

Уралдаан зохион байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 “а”, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалын 2.1.6, Сумын засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.5.1.4 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. “Эх хэлний өдөр”-ийг тохиолдуулан үндэсний бичгээ сурталчлах, түүгээр бахархах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор Ерөнхий боловсролын сургуулийн VI-XII ангийн сурагчдын дунд үндэсний бичгээр хичээнгүй тигээр эх бичих уралдааныг зохион байгуулсугай.

2. Уралдааны 1-р шатыг Ерөнхий боловсролын сургууль бүр 2 насны ангиллаар, 2-р шатанд шалгарсан бүтээлийг шалгуур үзүүлэлтийн дүгнэж, шалгаруулан олон нийтэд сурталчилна таниулахыг сумын Хэлний бодлогын салбар зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай.

3. Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 180000 (нэг зуун наян мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг тамгын газрын дарга (Ц.Лхагвасүрэн), ня-бо (О.Бямбасүрэн)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

С.БАТ-ОРГИЛ



Сумын засаг даргын 2021 оны 09 сарын 28 өдрийн
А/4/ дугаар захирамжийн хавсралт

№	төрөл	шагналын мөнгөн дүн	суутгал	гарт олгох
1	хичээнгүй бичиг (6-9р анги) I байр	40000₮	5%	38000₮
2	хичээнгүй бичиг (6-9р анги) II байр	30000₮	5%	28500₮
3	хичээнгүй бичиг (6-9р анги) III байр	20000₮	5%	19000₮
4	хичээнгүй бичиг (10-12р анги) I байр	40000₮	5%	38000₮
5	хичээнгүй бичиг (10-12р анги) II байр	30000₮	5%	28500₮
6	хичээнгүй бичиг (10-12р анги) III байр	20000₮	5%	19000₮
	Дүн	180000₮		171000₮